

САВ ШИМ ЕРТӨНЦ БА МОНГОЛ БИЧИГ

Ц.Буянхишиг, ХААИС, Дархан

Abstract: Since Chinggis Khaan declared the Mongolian script as the official state script in 1204, Mongolians have used it for approximately 1000 years. Therefore every one should study our culture of 1000 years and bequeath to our future generations. To accomplish this, a new methodology needs to be developed and tested. The next step is passing the methodology to teachers.

Our ancestors used the shapes of real beings/animals, humans and natural elements/of the Universe while they were creating the Mongolian script. Mongolians created some important conceptions about Human beings and the Universe in their philosophy. Psychology depends on our mongolian language. Human psychology is revived by language. Researching alphabet script and meaning will help students and their creative ideas.

The study found that the difference between writing and pronunciation in Mongolian script is big; some letters are similar to each other so they are difficult to identify. Also, it is difficult to write foreign words in script because the letters have different forms depending on their position in a word. The students usually face these challenges when they learn the Mongolian script. In order to overcome these challenges actional and experimental research was conducted with the "Sav Shim" method among the 7th -9th grades of the "Oyuniiireedui" complex school in Darkhan-uul province. The shapes and drawings of Mongolian letters are similar to objects of the earth. So "Sav-Shim" method uses these similarities. As the result, we designed eight unit lessons with three chapters titled "Hun-Ertonts", Sav-Ertonts", and "Shim-Ertonts".

The «sav shim» method to teach Mongolian script alphabet

Түлхүүр үг: Сав, шим, хүн ертөнц, монгол сэтгэхүй, үсэг зүй, дүрт сэтгэхүй, зураг.

Оршил

Бид монгол хүүхдэд удмын бичиг монгол хэлийг зааж сургахын тулд монгол хүүхдийн сэтгэхүй, монгол хүнийг таньж ойлгох хэрэгтэй. Монголчууд хорвоо ертөнцийг хүн ертөнц, сав ертөнц, шим ертөнц хэмээн тогтолцоот шинжээр нь бүхэлчлэн ойлгож монголын гүн ухаан болгож хэлэндээ дархалсан билээ. Тэгвэл энэ гурван ертөнц монгол бичгийн үсэгт хувиран хэлбэр дүрс, утга, бүтэц, хувиргал, хэрэглээтэйгээ байдгийг сурагчидтайгаа хамтран судалж үүнийгээ "Сав шим"-ийн арга хэмээн томъёолж байна. Хэл шинжлэлийн эрдэмтэн "Бидний монголчуудад тогтсон үсэг үгүйн тул газар газрын бичиг адил бус болох ба толгойлсон дохио үгүйн тул эрж олох эх адаг үгүй ямагт бусдын ном бичигт шүтэн дагалдаж явахын төдийгөөр өнгөрөх нь **даруй басагдлын орон мэт**" гэж 100 гаруй жилийн өмнө сануулж байсан (Лхамсүрэн, 1997, х.2). Амьтай бүхэн сүнстэй, амьгүй бүхэн эзэнтэй билээ.

Үндсэн хэсэг

Монгол үсэгзүйн бүрдэлд хүний бие эрхтний махбод бүрэн бүрдэхээс гадна зурлага, зураас, тиг, бэх, бийрийг амилуулж тэдгээрт сүнс оруулж хүн амьтныг амьд мэт амьдруулж, тэр ч байтугай тодорхой үйлдэл хөдөлгөөн хийлгэж дүрсэлж болдог. "Үсэг бүрийг ажин шинжвэл..эвэр

сэрийлгэж, сүүл матруулсан нь хилэгнэсэн луу өндөр мандал өөд тэмүүлэн дүүлэх мэт" гэж "Л" үсгийг хэлсэн. (Баттогтох, 2013, х.35). "Сав, шим"-ийн аргаар туршилт хийсэн ангийн хүүхдүүд лууны "Л" гэж олсон нь энэ үсгийг хэн ч харсан лууны дүрсээ өөртөө шингээсний шинж буюу. Ийнхүү монгол бичиг заах аргыг үсэглэврийн хэлбэр дүрс дотроос гаргаж авч болно. "Дүрсийг хэн яаж харна, хэрхэн сэтгэнэ, тэр хэмжүүрээр төсөөлөгдөн тэр нь бодит мэт ухагдахууны тусгал болж байдаг" гэсэн байдаг (Оюун, 2006, х.5).

Монголчууд энэхүү ертөнцийг сав, шим хэмээн тогтолцоот шинжээр нь ойлгох бөгөөд хүний тусын тулд энэ орчлон ертөнц байгаа гэж боддоггүй тул тэнгэр эцэг, газар эхээ их эртнээс судалж мэдээд ямагт хүндэтгэн хайрласаар ирсэн гүн ухаантай ард түмэн юм. Өөрөөр хэлбэл, Монголчууд орчлон ертөнцийн бүхий л үйл явц, үзэгдэл юмсыг "амь"-тайгаар төсөөлж, тэдгээртэй чин сэтгэлийн угаас гүн хүндэтгэлтэй харьцдаг байдал нь "Сав, шим"-ийн аргын гүн ухааны үндэс болно.

Монголчууд хүүхдийнхээ оюуны нэг чухал хэсэг болсон хараа харцанд нь илүүтэй анхаарч түүнийг зөв боловсруулахыг чухалчилдаг байжээ. "Сав шим" ертөнцийн бодит зүйлийг ажиглаж үсэг бүрийн дүрстэй адилтган бодол эргэцүүлэл хийж,


зурж, дүрсэлж, ярьж, уншиж, бичих, тайлбарлах үйл “Сав шим”-ийн аргын дидактикийн үндэс болно. Өөрөөр хэлбэл, аливаа юмын хэлбэр дүрсийг тухайн үсэг, үсэглэвэрт төстэй байгаа шинжээр нь тулгуурлаж зурах, дүрслэх замаар үсэг тогтоолгох нүдлүүлэх арга юм.

Монгол хүн аливаа юмыг нэгтгэн ерөнхийлж, дараа нь задлан тусгайлж сэтгэдэг, өөрөөр хэлбэл ерөнхийгөөс тусгайд шилжих сэтгэлгээний хэв маягтай гэж хэлж болно. Жишээ нь: Монгол бичгийн үсэг бүрийн дүрсийн утга, бүтэц, хувиргал зэргийг үндэслэн 3 бүлэг 8 нэгж хичээл болгож байна. Чингэхдээ ямагт нэгийг нөгөөгөөс ялгах буюу хувиргах, жишин харьцуулах, ажиглах замаар сэтгэхүйн үйлдлүүд хийж улмаар түүнээсээ оюун дүгнэлт гаргаж танин мэддэг. Үүнээс ажиг жиших нь танин мэдэхүйн түгээмэл энгийн арга бөгөөд ажигламтгай, жишимтгий чанар бол монгол хүний ахуй, аж амьдралаас үүдэлтэй, монгол хүний сэтгэлгээнд илүү давамгай хөгжсөн зэрэг нь “Сав, шим”-ийн аргын сэтгэл зүйн үндэс юм.

Бидний туршилт хийсэн 7-р ангийн 11-13 настай өсвөр насны хүүхэд бодит байдлаас хүртэж байгаа юм үзэгдлийг үлэмж нарийн задлан шинжилж, нэгтгэн дүгнэх чадвартай байдаг.

1. Хүн ертөнц” –ийн үсэг буюу эгшиг үсгүүд

Монгол хүн “малд нүдтэй” гэж ярьдаг. Энэ нь монголчуудын аливаа юмыг ажиглаж, харьцуулж байдаг шинж чанарыг хэлж байгаа бөгөөд Монгол бичгийн үсгийг зохиохдоо энэ чанараа их ашиглажээ. Дээрх эгшиг үсгүүд эхэн, дунд, адагт 3 өөр хэлбэр дүртэй, 7 эгшгийг хүн сэтгэлээ шингэн харилцах хэрэглүүр болгож чаддаг гэх мэт үндэслэлээр “Хүн ертөнц”-ийн үсэг болгож байгаа юм.



1.1 Шүдний А, Э нь “шүд” ᠰ ᠮ ff гэсэн зурмын нэртэй ба шүд нь ургаж эхлээд авиа, үг хэлж эхэлдэг гэсэн логикоор энэ нэрийг өгчээ. Хүүхэд, залуу үедээ шүд нь бүрэн байж байгаад хөгшин болохоор шүд нь унаж, шүдээ орхисон, шүдгүй болдог гэсэн утгаар адагт ордог “а” сүүл, орхиц хэлбэртэй байгаа юм. Гэтэл бид шүдний тухай ярьж байснаа сүүлний тухай яриад эхлэхээр логик холбоо нь алдагдаж хүүхэд төөрч эхэлдэг. “Шүдийг сунгавал сүүл, сүүлийг эвхвэл шүд” гэсэн хэлц байдаг нь шүд, сүүл гэсэн 2 зурмын нэр нь угтаа нэг зүйл гэдгийг баталж байгаа юм. Дээрх аргаар заахад үгийн төгсгөлд сүүл, орхиц хийлгүй шүд хийгээд байдаг алдаа 15-25% багассан байна. Аав, ах, эх, эгч гэх мэт ураг төрлийн үүсгэл ерөнхий утгыг заадаг ба сэлгэж болж байгаа тул нэг дор үзэх авианы утгын үндэс болж байгаа юм.

1.1.2 Шилбэний “И” эгшиг дүрстэй байгаа нь “шилбэ” гэсэн хүний гол тулгуур эрхтний нэр юм. Энэ нь залуу үедээ хөл, шилбэ нь тэгш байгаад хөгшин болоход нумарч мурийдаг дүрсийг үйл явцаар нь хэмээн дүрсэлжээ. Гэтэл бид шилбэний тухай ярьж байснаа “нум” гэж адагт орох “И”-г нэрлэж байгаа нь хүүхдийг гайхах, мэдсэн юмандаа эргэлзэх байдлыг төрүүлээд байна. “И” язгууртай үгний ерөнхий утга нь зөөлний тул муудах гэсэн ерөнхий утгатай байдаг. Үүний үр дүнд аль ч үед шилбэ бичдэг алдаа нь 18-22% багассан. Шүд байхдаа богино, шилбэ байхдаа урт болдог шинжээр нь А, Э, И үсгийг хослуулж нэг цагт заавал үр дүнтэй.

1.2 Гэдэсний “О, У, Ө, Ү”


/монгол бичигт гэдэстэй эгшиг кирил үсэгт уруулын эгшиг

Жишээ нь: Хавирган сарыг дуурайн зурсан “С” үсгийн хэлбэрийг эргэцүүлэн бодож ажиглаж зураад дараа нь “С” үсэг үгийн эхэн, дунд, адагт энэ хэлбэрээ өөрчлөхгүй байгаа нь хавирган сар тухайн тэр цаг мөчдөө дүрс үл урвадаг болохтой адилтгаж байгаа хэрэг юм. Ингэж “с” үсгийг сарны “с” хэмээн хийсвэрлэн сэтгэснээ дүгнэж байна. Ер нь хүүхдийн амжилттай сурахад тохиолддог нэгдүгээр саад “Масс” байхгүй байх буюу бодит юм, үзэгдэл нүдэнд харагдаж чихэнд сонсогдохгүй дэндүү хийсвэр байгаа нь өнөөгийн сургалтын дутагдалтай тал юм. Энэ насны хүүхдийн тухай “... ямар нэгэн дүрийг хурц тод зохиож дүрслэх чадвар хөгжсөн байдаг ба оюун ухаандаа бодож дүрсэлсэн дүрийг үг яриагаар хурц тод уран илэрхийлэлтэй гаргаж чадна.” гэжээ (Жамц, 2013, х.203). Монгол бичгийн үсгүүдийн утга, бүтэц, хувиргалыг “Сав, шим” ертөнцийн дүр төрх, хувирал өөрчлөлт, болц явцтай харьцуулан 3 бүлэг 8 нэгж хичээл болгосныг товч өгүүлэе. Ингэхдээ “Сав шим”-ийн аргын гүн ухаан, сэтгэл зүй, дидактик, хэл шинжлэлийн үндсийг гаргаж түүн дээрээ тулгуурлан өсвөр насны хүүхдийн сурах арга барил, сэтгэл зүйд хэрхэн нөлөөлж байгааг тооцон үзсэн болно.

байдаг/ дээрх дүрстэй байгаа нь хүн хүүхэд, залуу цагтаа нуруу тэгш, гэдэс зуувандуу байдаг бол хөгшрөөд ирэхээрээ нуруу нь бөгтийж гэдэс нь унждаг байгалийн жам ёсыг харьцуулах жиших аргаар харуулжээ. Ингэж заахад үгийн сүүлд гэдэс бичээд нумыг нь орхидог алдаа 15-20% багассан байна. Үгийн нэгдүгээр үед О, Ө хэлдэг нь О язгуур нь” оюун ухаан”, Ө язгуур нь “өөдөө дээшээ” гэсэн утгатай бүлэг үгүүдийн ерөнхий утга байдаг. Харин нэгдүгээр үеэс бусад үед У, Ү хэлж байгаа нь “уруудах, унжих, үрчийх” гэсэн утгатай бүлэг үгийн ерөнхий язгуур болохоор тэр юм. Тиймээс ч хүний эрхтэн бүхий дуудлага ижил, дүрс ондоо үгсийг ялгахдаа үгийн эцэст гэдэстэй нум бичсэн байдаг. Жишээлбэл, дал мөрний дал гэхэд “Далу”, “мөрү” гэж гэдэстэй нумаар төгсгөж бичдэг. Ингэж дүрсийн утга, авианы утга хоёр яв цав таарч байгаа нь монгол бичгийн гайхамшиг бөгөөд хүний амьдралын 3 үеийг дүрсээр ойлгуулж байна. Өөрийгөө таньж, судалж өөртөө үнэлэлт дүгнэлт өгч эгшиг авиаг сурах бөгөөд энэ нь биеэрээ юмыг хэмждэг монгол аргын эх үүсвэр байна.

2. “Шим ертөнц” –ийн үсэг буюу Ж-З, Т-Д, Х-Г үсгүүд

Данзандагва: “Юуны тул утгасыг тодруулагчийн тул (Данзандагва, 1997, х.12). толгойн дээрх үсгүүд нь эхэндээ ижил дүрстэй байгаа нь шим бодит үйл, болц явцыг харж нэгэн тэмдгээр төлөөлөн сэтгэх



гийгүүлэгч хэмээвээс үгс тийн хэмээн өгүүлбэй” гэжээ Монгол бичгийн цагаан нэг дүрстэй, дунд адагтаа нэг ертөнцийн ургамал, амьтны дүрсэлжээ. “Бодит юмсыг ямар нь хийсвэр сэтгэхүй хөгжихөд

маш чухал алхам болдог” гэжээ (Жавзан, 2009, х.225). Лувсанчойнхор ”урвах”, Лхамсүрэн “Үсгийн хэлбэр адил бөгөөтөл дуудах аялгуу өөр болох буйн тул тэдгээр зургаан үсгүүдийг тус тус таниулан тодорхойлвоос.” гэх мэтээр эртний хэл зүйн бичгүүдэд эдгээр 6 үсгийг хоёр хоёроор нь заах арга зүйг бичсэн байна. Ж.Пиаже хүүхдийн сурах үйл явцыг сэтгэл зүйн ухаанд тулгуурлан нарийвчлан судлаад “хүүхэд мэдээллийг цээжилж суралцдаггүй, шинэ мэдээлэлтэй ажиллах замаар өөрийн бүтээлч үйл ажиллагаагаар мэдлэгээ бүтээн суралцдаг” гэж үзжээ (Пүрэвдорж, 2013, х.82).

2.1 Жимсний “Ж” / З/ үсэг

Өвс урт нарийн ургах бөгөөд ишнээс нь булцруу үүсч боловсорч эхэлдэг дүр зураг буюу жимсний ургах үе, болох үе харагдаж байгаа юм. Тарианы “Т” /Д/ үсэг гэж бичиж байгаа нь мөн тарианы ургах явц, болох үеийн үйл явцыг дүрсэлжээ.


2.2 Хулангийн “Х” /Г/ үсэг.

Хуланболадууны дээд өвөг бөгөөд монгол хүнийг аль ч цаг үед морьгүйгээр төсөөлөх аргагүй юм. Энэ амьтны эрийг нь азарга, эмийг нь гүү гэж нэрлэдэг нэрлэлтээс эр эм үгний Г,Х үсэг ялгарч гарсан.

Дээрх дүр нь эр амьтан үр төлөө өөрийн биеэс гадна асарч энхрийлдэг гэсэн санаа бөгөөд Хө, Гө, Хү, Гү нь нуман дотроо гэдэс нь багтаж байгаа нь эм амьтан үр төлөө гэдсэндээ тээдэг гэсэн санаа юм. Энэ санааг олсноос хойш эм үгэнд нумны гадна гэдэс хийдэг алдаа 16-28% буурч зөв бичих болсон.

3. “Сав” ертөнцийн үсэг буюу Н, С, М, Л, Б, Ц, Р, Е үсгүүд

Дээрх үсгүүд эхэн, дүрстэй байгаа нь сав цаг үедээ дүрс үл Эдгээр дүрсг үсэгнүүд их хувь буюу 50% байгаа



дунд, адагтаа нэг л ертөнцийн юмс тухайн урвадагтай адил юм. нь бүх үсгийн хамгийн нь монголчууд дээд

тэнгэрээ шүтэж ирсэнтэй холбоотой бөгөөд бидний өвөг дээдэс тэнгэрийг унших буюу ажих ухаан эрт үүссэнтэй холбоотой байх.

3.1 Нарны /Н/ М М ff үсэг.

Нар бол орчлонгийн нэг гэрэлт од бөгөөд энэ цэгийг томруулж харвал нар шиг л бөөрөнхий. Сарны /С/ /ш/ М М ff үсэг. Хавирган сарны хэлбэрийг дуурайлгаж бүтээсэн энэ үсгийг завьж гэж таниулж байгаа нь бүтцийг нь хэлж байгаа хэрэг юм

3.2 Лууны /Л/ М М үсэг.

Тэнгэрийн “луу” гэдэг амьтан сүр хүч ихтэй бөгөөд “Л” үсэгний бичлэг тухайн бодит зүйлтэйгээ утгын хувьд таарч байгаа юм. Ялангуяа сүүлд орсон “Л” нь лууны дүрсийг дурайтал зурсан байгаа. Хүннүгийн булшнаас лууны дүрстэй эд өлгийн зүйлийг археологичид олныг олсон. Солонгын /М/ М М үсэг. Борооны дараа бий болдог солонгын дүр хэлбэр буюу утгын тал нь “М” үсэгний дүрстэй тохирч байгаа юм. Дусал, эвэр, гэзэгний цаад учрыг олсны дараа

сурагчид эдгээр дүрсийг орхиж, салгаж бичдэг алдааг 30-35% хүртэл гаргахгүй болсон байна.

3.3 Борооны /Б/ үсэг. Борооны орох үйл явц, борооны дусалны хэлбэр, кирил үсэгний “Б”-тэй адилдуу тал зэргийг ажиглаж ойлгосны дараа хүүхдүүд нумны гадна талд гэдэс бичдэг алдааг 30-35% гаргаагүй. Цасны /Ц, ч/ М М ffj үсэг. Цас орох үйл явц, цасан ширхэгний хэлбэр, кирил үсэгний “Ц”-тэй адилдуу тал зэргийг ажиглаж ойлгосны дараа монгол бичгийн /Ж/ үсэгтэй андуурах, буруу бичиж алдаа гаргах нь 20-25% багассан байна.

3.4 Рашааны /Р/ М М ffj үсэг. Рашааны урсах, долгилох үйл явцыг дүрсэлж үзүүлжээ. Дээрх үсгийн билэгдэлт нэрүүд нь дандаа эр үг байгаа нь бид тэнгэр эцэг гэж нэрлэдэгтэй утгын холбоотой. Ертөнцийн /Е/ М М ffj Шилбэ долгионтой эрээлжилсэн дүрстэй “Р” үсэг, шилбэний үзүүр дээшээ матигар дүрстэй “Е” зэрэг бичлэгийн талыг ажиглуулж нэг цагт зэрэг заавал үр дүнтэй байсан. Урт настай ертөнц нэгэн хэвэндээ эргэлдэж байдаг тул дээшээ матигар буюу үл зогсох, үл тасрахын билгэдэл юм. Мөн хас тэмдгийг салгавал 4 “Е” үсэг болно. Хас тэмдэг нь орчлон, ертөнц гэсэн утгатай байдаг. Дээрх сав ертөнцийн үсгүүдийг нар-сар, луу-солонго, бороо-цас, рашаан-ертөнц гэсэн логик учир холбогдолоор нь нэг цагт заавал үр дүнтэй байсан. Арга, билэг хоёр үргэлж нэгдэн хөгжлийг бий болгож байдаг мөнхийн хөдөлгүүр болно. Ингээд бид монгол цагаан толгойн үсгээ “Сав шим”-ийн аргаар 3 бүлэг 8 нэгж хичээл болгон үзэж дууслаа. Ийнхүү нэгжийг томсгох буюу бүлэглэж заах аргаар заах нь монгол хүний сэтгэхүйн гүн ухааны онцлог дидукцид буюу ерөнхийгөөс хэсэгт чиглүүлж оюун дүгнэлт хийдэг сэтгэлгээний хэв маягтай тохирч байгаа юм. Сурагчдын хийсэн бүтээлээс толилуулья.



“Сав, шим”-ийн аргаар монгол бичиг сурсан сурагчдын оюуны зураглал. 2013 оны 8^о анги.



“Сав шим”-ийн аргаар хийсэн үсгийн сан. 2013 оны 8^о анги

Хүснэгт 1
“Сав шим”-ийн аргын тохирцын дүн. /8^о анги/

д/д	Дүн	Үнэлгээ	Унших чадвар		1 мин унших чадвар		Бичих чадвар		Сонсох чадвар	Эргэцүүлэн асуулт тавих	Бусад чадвар	Бүгд
				т/б	т	т/б	т	т/б				
1	Бүгд	Багш	116	92	121	87	106	87	131	123	109	974
2	Гүйцэтгэл %		72	65	75	54	66	62	93.5	76	68	68
1	Бүгд	БСГ, СТТШ	155	88	113	89	112	84	128	118	117	964
2	Гүйцэтгэл %		96.8	55.0	70.6	55.6	70	52.5	80	73.7	73.1	66.9
	Зөрүү		+24,	-10	-4,4	+1,6	+4,1	-9,5	-13,5	-2,5	+5,1	1,1

Тайлбар: т-танил сэдэв, т/б-танил бус сэдэв

Дээрх зөрүүнүүдийг ажиглахад бүх зөрүүний 77,7% нь 10 буюу түүнээс доош зөрүүтэй байгаа нь дээрх аргаар сургалт зөв явагдаж байгааг харуулж байгаа юм. Энэ нь багшийн шалгалтын гүйцэтгэл 68% байхад, хөндлөнгийн шалгалтын гүйцэтгэлийн хувь 66,9% буюу зөрүү нь 1.1 байгаагаар батлагдаж байна. Хяналтын анги 8-6, туршилтын анги 8-9 ийн сурлагын дүн.

Хүснэгт 2

Д	Анги	Улирал	Бүгд	А	В	С	D	F	Амжилт	Чанар
1	8-6	1	36	15	6	10	2	3	91,6	58,3
2	8-9		41	21	11	7	2	0	100	80,4
3	Зөрүү								+8,4	+21,6
4	8-6	1	36	6	13	9	4	4	88,8	52,7
5	8-9		40	26	10	3	1	0	100	90
6	Зөрүү								+11.2	+37.3
7	8-6	2	36	11	9	10	3	3	91,6	55,5
8	8-9		40	23	9	6	2	0	100	80
9	Зөрүү								+8,4	+24,5
10	8-6	2		10	10	5	9	2	94,4	55,5
11	8-9			26	7	8	0	0	100	80,4
12	Зөрүү								+5,6	+24,5

1.Тухайн 2 ангийн амжилтын зөрүү 10 % -аас их хол зөрөхгүй байгаа нь тухайн багш сургалтаа сайн хөтөлж явуулж байгаагийн илрэл юм. 2.Чанарын зөрүү 21-37% байгаа нь “Сав шим”-ийн арга сурлагын чанарт сайнаар нөлөөлж байгааг харуулж байна.

Дээрх аргаар заасан хичээлийн статистик шинжилгээний дүн:

Хувилбарын үүсвэр	SS	df	MS	F	P-дүн	критек утга
В хүчин зүйлийн квадратын нийлбэр ба дисперс /багууд/	119,46	39,00	3,06	9,29	0,00	1,44
А хүчин зүйлийн квадратын нийлбэр дисперс /чадварууд/	56,49	8,00	7,06	21,42	0,00	1,97
Үлдэгдэл дисперс	102,84	312,00	0,33			
Ерөнхий дисперс	278,79	359,00				

/Багшийн үнэлгээ/ MS Excel-программын /Тоон шинжилгээ хийх/ дэд программ ашиглан давталтгүй хоёр хүчин зүйлийн шинжилгээ хийхэд мөрөөр Фишерийн утга $F=9,29 > F_{crit}=1,44$ онолын утгаас их буюу багуудын хооронд хүчин зүйлийн нөлөөлөлтэй.

Мөн баганаар Фишерийн утга $F=21,42 > F_{crit}=1,97$ онолын утгаас их буюу чадваруудын хүчин зүйлийн нөлөөлөлтэй.

Чадваруудын хооронд корреляцийн хамаарлын хүснэгт /багшийн үнэлгээ/

	Унших чадвар	Танил биш	1 мин унших чадвар	Танил биш	Бичих чадвар	Сонсох чадвар	Эргэцүүлэн асуулт тавих чадвар	Бусад чадвар	
Унших чадвар	1								
r1 Танил биш	0,74	1							
r2 1 мин унших чадвар	0,71	0,65	1						
r3 Танил биш	0,62	0,64	0,71	1					
r4 Бичих чадвар	0,71	0,61	0,55	0,63	1				
r5 Танил биш	0,60	0,56	0,47	0,44	0,66	1			
r6 Сонсох чадвар	0,38	0,39	0,25	0,37	0,29	0,36	1		
r7 Эргэцүүлэх	0,59	0,53	0,36	0,47	0,51	0,38	0,62	1	
r8 Бусад чадвар	0,35	0,33	0,22	0,30	0,33	0,18	0,45	0,36	1

/Багшийн үнэлгээ/ MS Excel-програмын /Тоон шинжилгээ хийх/ дэд програм ашиглан чадваруудын хооронд корреляцийн шинжилгээ хийж үзэхэд:

$r_1=0,74$ буюу унших чадвартанил биш сэдвээс унших чадвар хоёр хүчтэй хамааралтай.

$r_2=0,71$ буюу унших чадвар 1 мин унших чадвар хоёр хүчтэй хамааралтай.

$r_4=0,71$ буюу унших чадвар бичих чадвар хоёр хүчтэй хамааралтай.

$r_6=0,38$ буюу унших чадвар сонсох хоёр сул хамааралтай.

$r_7=0,59$ буюу унших чадвар эргэцүүлэн асуулт тавих чадвар дунд зэргийн хамааралтай.

$r_8=0,35$ буюу унших чадвар бусад чадвартай сул хамааралтай.

Хувилбарын үүсвэр	SS	df	MS	F	P-дүн	критек утга
В хүчин зүйлийн квадратын нийлбэр ба дисперс /багууд/	145,66	39,00	3,73	8,66	0,00	1,44
А хүчин зүйлийн квадратын нийлбэр дисперс /чадварууд	49,39	8,00	6,17	14,31	0,00	1,97
Үлдэгдэл дисперс	134,61	312,00	0,43			
Ерөнхий дисперс	329,66	359,00				

/Хөндлөнгийн үнэлгээ/ MS Excel-програмын /Тоон шинжилгээ хийх/ дэд програм ашиглан давталтгүй хоёр хүчин зүйлийн дисперсийн шинжилгээ хийхэд мөрөөр Фишерийн утга $F=8,66 > F_{crit}=1,44$ онолын утгаас их буюу багуудын хооронд хүчин зүйлийн нөлөөлөлтэй.

Мөн баганаар Фишерийн утга $F=14,31 > F_{crit}=1,97$ онолын утгаас их буюу чадваруудын хүчин зүйлийн нөлөөлөлтэй.

Чадваруудын хооронд корреляцийн хамаарлын хүснэгт /хөндлөнгийн үнэлгээ/

	Унших чадвар	Танил биш	1мин унших чадвар	Танил биш	Бичих чадвар	Танил биш	Сонсох чадвар	Эргэцүүлэн асуулт тавих чадвар	Бусад чадвар	
	Унших чадвар танил биш	1								
r1	Танил биш	0,79	1,00							
r2	1мин унших чадвар	0,81	0,73	1,00						
r3	Танил биш	0,61	0,69	0,82	1,00					
r4	Бичих чадвар т	0,75	0,65	0,68	0,47	1,00				
r5	Танил биш	0,59	0,68	0,60	0,58	0,72	1,00			
r6	Сонсох чадвар	0,40	0,24	0,46	0,26	0,45	0,22	1,00		
r7	Асуулт тавих чадвар	0,31	0,02	0,35	0,08	0,54	0,18	0,64	1,00	
r8	Бусад чадвар	0,32	0,15	0,24	0,09	0,19	0,11	0,55	0,35	1,00

/Хөндлөнгийн үнэлгээ/ MS Excel-програмын /Тоон шинжилгээ хийх/ дэд програм ашиглан чадваруудын хооронд корреляцийн шинжилгээ хийж үзэхэд:

r1=0,79 буюу унших чадвар танил биш сэдвээс унших чадвар хоёр хүчтэй хамааралтай.

r2=0,81 буюу унших чадвар 1 мин унших чадвар хоёр хүчтэй хамааралтай.

r4=0,75 буюу унших чадвар бичих чадвар хоёр хүчтэй хамааралтай.

r6=0,40 буюу унших чадвар сонсох хоёр сул хамааралтай.

r7=0,31 буюу унших чадвар эргэцүүлэн асуулт тавих чадвар сул хамааралтай.

r8=0,32 буюу унших чадвар бусад чадвартай сул хамааралтай.

Туршилт хийсэн 8-9 анги, хяналтын 8-6 ангийн монгол бичгийн хичээлээр авсан шалгалтын үр дүнд /2013-2014 оны хичээлийн жил 1-р улирал 2-р шалгалт/MS Excel-ийн /Тоон шинжилгээ хийх/ дэд програм ашиглан тэнцүү биш дисперстэй хоёр түүврийн дунджийг жиших t тестийн шинжилгээг хийж үзэхэд:

t-Тэст : Хоёр –загвар бодох -тэнцүү бус Дисперс

	8-6	8-9
Дундаж	86,11	91,17
Дисперс	29,88	36,09
Ажиглалтын тоо	19,00	36,00
Таамаглал	0,00	
Чөлөөний зэрэг	40,00	
Стьюдентийн тест	-3,15	
P(T<=t) магадлал	0,00	
Нэг талт онолын утга	1,68	
P(T<=t) магадлал	0,00	
Хоёр талт онолын утга	2,02	

$|tstat| = |-3,15| = 3,15 > t_{crit} \quad two = 2,02$ stastic модулиараа онолын утгаас их буюу туршилтын анги жирийн ангийн дунджууд мэдэгдэм ялгаатай.

Мөн $tstat = 3,15 < t_{critical} \quad one = 1,68$ буюу туршилтын ангийн дундаж **91,17** жирийн ангиас дунджаас **86.11**-ээс их болох нь онолоор батлагдаж байна. Туршилт үр дүнтэй гэсэн дүгнэлт гарч байна.

Туршилт хийсэн 8-9 анги, хяналтын 8-6 ангийн монгол бичгийн хичээлээр авсан шалгалтын үр дүнд /2013-2014 оны хичээлийн жил 2-р улирал 2-р шалгалт/ MS Exsel-ийн /Тоон шинжилгээ хийх/ дэд програм ашиглан тэнцүү биш дисперстэй хоёр түүврийн дунджийг жиших t тестийн шинжилгээг хийж үзэхэд:

t-Тэст : Хоёр –загвар бодох -тэнцүү бус Дисперс	8-6	8-9
дундаж	88,30	92,21
Дисперс	34,54	34,11
ажиглалтын тоо	20	33
Таамаглал	0	
чөлөөний зэрэг	40	
Стьюдентийн тест	-2,35	
$P(T \leq t)$ магадлал	0,01	
нэг талт онолын утга	1,68	
$P(T \leq t)$ магадлал	0,02	
хоёр талт онолын утга	2,02	

$|t_{stat}| = |-2,35| = 2,35 > t_{crit} \text{ two} = 2,02$ static модулиараа онолын утгаас их буюу туршилтын анги жирийн ангийн дунджууд мэдэгдэм ялгаатай.

Мөн $t_{stat} = -2,35 < t_{critical} \text{ one} = 1,68$ буюу туршилтын ангийн дундаж **92,21** жирийн ангиас дунджаас **88,30**-ээс их болох нь онолоор батлагдаж байна. Туршилт үр дүнтэй гэсэн дүгнэлт гарч байна.

ДҮГНЭЛТ

Дүрсэлж загварчлах арга бол мэдээлэл боловсруулах, танин мэдэхүйн үйлийг хөтлөн дэмжих, суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагад чанарын өөрчлөлт, ахиц дэвшил гаргах, “Монгол бичиг”-ийн хичээлийн сургалтын технологийг боловсронгуй болгох дэвшилтэт аргын нэг гэж үзэж, уул аргыг хэрэглэсэн туршилт судалгааг доорхи байдлаар товчоолон дүгнэж байна.

Үүнд: “Сав шим”-ийн аргаар хийсвэр загвар гарган ашигласнаар суралцагч хамгийн хүнд сэдэв болох монгол бичгийн үсгүүдийн бичлэг дуудлагын зөрөөтэй байдал, зарим үсэг хоорондоо адилхан тул ялгахад бэрх, нэг үсэг 3 өөр үед, 3 өөр дүрсээр бичигддэг тухай мэдлэгийг хамтран бүтээж, тулгарсан асуудал дээр төвлөрөн, сурч танин мэдэх сэдэл тэмүүлэл, хүсэл сонирхол бий болж, хичээлийн явцад бүгд идэвхтэй оролцон, сурлагын хоцрогдол арилж, амжилт ахисан болно.

Сав шим ертөнц талаасаа бол энэ нь биет загвар буюу орон зайн бодит загвар, дүрслэл болж байгаа учраас тэнд бодит дүрийн сэтгэхүй давамгайлж, суралцагчийн сурах идэвх сонирхлыг дээшлүүлж, мэдлэгийг албадлагагүй, зориудын бус ойт огтоолтоор санамсаргүй байдлаар эзэмшүүлдэгээрээ давуу талтай болохыг туршилтын дүн нотлон харуулж байна.

“Сав, шим”-ийн аргаар монгол бичгийн цагаан толгой сурсан хүүхдэд сониуч байдал, хүсэл эрмэлзлэл буюу идэвхижүүлэлт, алсын хараа, шүүмжлэлт сэтгэлгээ, өөртөө итгэлтэй байдал, тэвчээр хатуужил, эерэг хандлага буюу үзэл бодол, мэдрэмжтэй байдал зэрэг бүтээлч сэтгэлгээний элементүүд бий болж байна

Суралцагч сурах үйл ажиллагаанд суралцаж, аливаа мэдээллийг тэмдэгт дохионы тогтолцоонд шилжүүлэн, загварчлан дүрсэлж сэтгэж чаддаг болсноор хичээлийн зорилго-үр дүн амжилттай биелж, Монгол бичгийн хичээлийн технологийн оновчтой хувилбарууд бий болгох боломж бүрдэж байна.

Монгол бичгийн үсгүүдийн утга, бүтэц, хувиргалтыг сав шим ертөнцийн дүр төрх, хувирал өөрчлөлт, болц явц, монгол ахуй, нөхцөлтэй хамтатган харьцуулан дүрсэлж загварчилснаар бэхжин хадгалах зан үйл-суралцагчийн урт хугацааны ой тогтоолт үүсэх нөхцөл болдог нь тодорхой болж байна.

Хүн бүр өөр өөр байдлаар хүлээн авах, сурах системтэй болохын зэрэгцээ, эдгээрийнхээ нэгэнд нь илүү сайн байдаг.

Өөрөөр хэлбэл “Дүрсний мэдрэмж илүү хөгжсөн тархи” буюу харах ой санамж сайтай, “дууны мэдрэмж илүү хөгжсөн тархи” буюу сонсох ой санамж сайтай, “хүрэх мэдрэмж илүү хөгжсөн тархи” буюу хүрэлцэх ой санамж сайтай гэж нэрлэж хувааж болох бөгөөд “Сав, шим”-ийн аргаар бүх хүүхэд монгол бичгээ сайн сурч болох юм гэсэн үг.

“Сав шим”-ийн аргаар туршилт хичээл явуулсан ангийн сурагчид баяр хөөр, аз жаргал, хүсэл тэмүүлэл, итгэл найдвар, урам зоригтойгоор хичээлээ хийж байсан нь энэ аргын хамгийн чухал давуу тал юм.

Цаашид дэвшүүлэх санал. “Сав шим” ертөнц нь хүнд дүрс судлал буюу хэлбэрийн дүрслэл гэдэг ойлголт өгдөг учраас ертөнцийн хэлбэр, бүтцийг монгол бичгийн цагаан толгойн үсгийн

хэлбэр, дүрстэй адилтган суралцагчийн сонирхол хэрэгцээ, нас сэтгэцийн онцлогт нийцсэн орчин үеийн техникийн хөгжил, орон зайн төсөөлөл, 4D хэлбэрээр өнгө, зураг, хөдөлгөөний гайхамшигтай шийдэл цогц байдлаар хамтатган судлуулах шаардлагатай байгаа бөгөөд сургах үйл явцыг төлөвлөх, хэрэгжүүлэх болон багш, суралцагч хоёрын хамтын үйл ажиллагааг хамгийн үр дүнтэй зохион байгуулах арга нь биет загвараар дүрслэх арга болохыг бидний туршилт судалгааны ажлын үр дүн нотолж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Баттогтох, Д. (2013). Монгол бичгийн гайхамшиг оршвой. Улаанбаатар: Мөнхийн үсэг
- Данзандагва, Р. (1997). Зүрхний толтын тайлбар огторгуйн маань хэмээх судар оршивой. *Монгол хэл шинжлэлийн дурсгал*. Улаанбаатар
- Жавзан, Б. (2009). *Боловсролын сэтгэл судлал*. Улаанбаатар: Мөнхийн үсэг
- Жамц, Л. (2013). *Ерөнхий сэтгэл судлал*. Улаанбаатар: Өнгөт хэвлэл
- Лхамсүрэн, Ч. (1997). Монгол үсгийн ёсыг тодорхойлон гаргасан алтан толь хэмээгдэх оршивой. *Монгол хэл шинжлэлийн дурсгал*. Улаанбаатар
- Пүрэвдорж, Ч. (2013). *Багшлахуйн менежмент*. Улаанбаатар: Мөнхийн үсэг
- Оюун, Ц. (2006). Авиа, үсгийн бэлгэдэлт чанарын тухайд. *Монгол судлалын чуулган*. Улаанбаатар